



“Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн барилаа

“Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр 2013 оны 1 дүгээр сарын 7-ны өдөр УИХ-д өргөн барилаа.

Үнэт цаасны зах зээлийг зохицуулах эрх зүйн үндсэн баримт бичиг болох “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийг анх 1994 онд баталж, 2002 онд шинэчлэн найруулж өнөөдрийг хүртэл даган мөрдөж байна.

Үнэт цаасны зах зээлийн хөгжлийг даган сүүлийн жилүүдэд компаниуд шинээр үнэт цаас гаргах, дотоод болон гадаадын зах зээлээс хөрөнгө татах эрэлт, хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулан үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчдод тавигдах шаардлагыг нэмэгдүүлэх, анхан шатны үйлчилгээний стандарт, зохион байгуулалтыг сайжруулах зэргээр хууль, эрх зүйн орчинг шинэчлэн боловсронгуй болгох шаардлага тулгарч байгаа юм.

Тиймээс “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, үнэт цаасны зах зээлийн ил тод байдал, үнэт цаасны зах зээлд оролцох, үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагын төрөл, бүртгэлийн үндсэн дээр эрхлэх үйл ажиллагаа, тавигдах нөхцөл, шаардлагыг шинээр тогтоож нарийвчилсан дүрэм журмаар зохицуулахаар заасан байна. Мөн төрийн эрх бүхий байгууллага, үнэт цаасны зах зээл дэх бүрэн эрх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төрөл, хэлбэр, ялгааг заахаас

гадна өөрийгөө зохицуулах байгууллагын эрх зүйн байдлыг тодорхойлж, тэдгээрийн бүрэн эрх, гишүүнчлэлийн асуудал зэргийг тусгажээ.

Үүний зэрэгцээ үнэт цаасыг нийтэд санал болгоход тавигдах шаардлага, танилцуулгад тусгах мэдээлэл, уг ажиллагаанаас үүсэх эрсдэлийг бууруулахад чиглэсэн хариуцлага, олон нийтэд мэдээлэх үүрэг, суурь үнэт цаасыг үндэслэн хадгаламжийн бичиг гаргахтай холбогдсон харилцааг нарийн тодорхойлсон байна.

“Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн хууль, эрх зүйн орчин олон улсын жишигт нийцэн хөгжихөд маш чухал алхам болох юм.


Хөрөнгийн зах зээлийн нээлттэй өдөрлөг болно

2013 оны 1-р сарын 26-ны өдөр Монголын хөрөнгийн биржийн санаачлагаар дотоодын ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ҮҮСЧ ХӨГЖСӨНИЙ 22 ЖИЛИЙН ОЙГ ТОХИОЛДУУЛАН “ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨДӨРЛӨГ”-ийг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн байранд зохион байгуулахаар болоод байна. Өдөрлөгт Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороо, Үнэт цаасны төлбөр, тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв, Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, Брокер, дилерийн компаниуд болон төлбөр, тооцоо гүйцэтгэгч банкууд оролцож данс шүүх, ноогдол ашгийн мэдээлэл өгөх, арилжаа болон хувьцаат компанийн мэдээлэл өгөх, брокерийн данс нээх, төлбөр тооцооны данс нээх, үнэт цаастай холбоотой иргэдийн санал гомдлыг бүртгэж авах, хөрөнгө оруулалтын зөвлөгөөг өгөх зэрэг нэг цэгийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлнэ.

Мэдээний тойм:

- “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн барилаа.
- Хөрөнгийн зах зээлийн нээлттэй өдөрлөг болно
- Зах зээлийн мэдээ
- Засгийн газрын зарим бондуудын үндсэн болон хүүгийн төлбөр бүрэн төлөгдлөө
- Бүртгэлтэй компаниудын мэдээ
- Үнэт цаасны зах зээлийн анхан шатны мэдлэг олгох сургалт 2013 оны 01 сарын 17-ны өдөр эхэлнэ

TOP-20 индексийн үзүүлэлт /сүүлийн 2 долоо хоногт/



2013 оны 1 дүгээр сарын 02-ноос 2013 оны 1 дүгээр сарын 11-ний хооронд нийт 9 удаагийн арилжаа явагдаж, 68 компанийн 987.9 сая төгрөгийн үнийн дүн бүхий 2.4 сая ширхэг хувьцаа арилжсан байна.

Тус хугацаанд хамгийн идэвхтэй арилжигдсан компани нь “Ремикон” ХК /307.1 сая.төг/, “АПУ” ХК /159.9 сая.төг/, “Би Ди Сек” ХК /147.8 сая.төг/ байсан байна.

Зах зээлийн мэдээ

Үнэт цаасны арилжаа

2 долоо хоногийн:

Арилжигдсан ширхэг	2.4 сая
Арилжигдсан дүн	987.9 сая.төг
Арилжигдсан компанийн тоо	68
Хамгийн их өсөлттэй:	Цагдуултай /HAM/ +74.64%
	Нако түлш /NKT/ +28.12%
	Монгол савхи /UYN/ +22.9%

Хамгийн их бууралттай:

Жуулчин говь /JGV/	-13.46%
Шивээ овоо /SHV/	-12.15%
Адуунчулуун /ADL/	-11.26%

Зах зээлийн үнэлгээ:

1,819.6 тэрбум.төг

TOP-20 индексийн өөрчлөлт:

18,103.85 / +2.2%

Индекс:

TOP-20

Вебсайт:

www.mse.mn



Засгийн газрын зарим бондуудын үндсэн болон хүүгийн төлбөр бүрэн төлөгдлөө

Монгол Улсын Сангийн яамнаас 2011 оны 6 дугаар сарын 8-ны өдөр тус бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1015 кодтой 70000 ширхэг, 1084 кодтой 30000 ширхэг, 1085

кодтой 20000 ширхэг Засгийн газрын бондууд гаргаж Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны арилжаагаар арилжаалсан тус бондуудын үндсэн болон хүүгийн төлбөр нь бүрэн

төлөгдөсөн тул Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2013 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 6 тоот тушаалаар үнэт цаасны бүртгэлээс хаслаа.

“Дархан гурил тэжээл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 6.1.1, “Компанийн тухай хууль”-ийн 57.1, “Үнэт цаасны зах зээл”-ийн тухай хуулийн 11.2, 34.1.8, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцааг заавал болон сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргах ажиллагааны журам”-ын 2.1 дэх

хэсгийн заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос “Дархан гурил тэжээл” ХК (MSE : DAR) -ийн нийт гаргасан 614,603 ширхэг хувьцааны 64.82 хувь буюу 398,386 ширхэг хувьцааг эзэмшигч нэгдмэл сонирхолтой этгээд болох С.Намсрайжав, Д.Балдан-Очир, Б.Түвшинтөр, Б.Түвшинжаргал, Г.Баярт нараас тус хувьцаат

компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа нийт хувьцааны 35.18 хувь буюу 216,217 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 1032 / нэг мянга гучин хоёр/ төгрөгөөс доошгүй үнээр худалдан авах санал гаргасныг зөвшөөрч хүчинтэй байх хугацааг 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн ажлын 60 хоног байхаар тогтоол гаргав.

“Хурх гол” ХК-ийн үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлээс хаслаа

“Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай” хуулийн 6.1.1, “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 34.1.1, “Компанийн тухай” хуулийн 23 дугаар зүйл, СЗХ-ны “Нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх, үнэт цаасыг анхдагч зах зээл дээр санал

болгох, худалдах тухай” журмын 8.1 дэх заалтыг тус тус үндэслэн СЗХ-ноос 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 337 тоот тогтоолоор “Хурх гол” (MSE:HRH) ХК-ийн үнэт цаасыг үнэт цаасны бүртгэлээс хасах тухай шийдвэр гаргасан байна. “Хурх гол” ХК нь зохион

байгуулалтын хэлбэрээ өөрчилж хязгаарлагдмал хариуцлагатай компани болж байгаатай холбогдуулан “Хурх гол” ХК-ийн гаргасан нийт 153,365 ширхэг үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлээс хаслаа.

“Аргай бэст” ХХК-ийн брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болголоо

Монгол Улсын “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 14.1.4, “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 27.3.2, СЗХ-ны “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 8.2.8

дахь заалтуудыг тус тус зөрчсөн үндэслэлээр МХБ-ийн гишүүн “Аргай бэст” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг СЗХ-ны 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 374 тоот тогтоолоор хүчингүй

болгосон байна. Үүнтэй холбогдуулан СЗХ-ны Улсын байцаагчийн 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 177 тоот албан шаардлагаар тус компанийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг зогсоогоод байна.

Үнэт цаасны зах зээлийн анхан шатны мэдлэг олгох сургалт 2013 оны 01 сарын 17-ны өдөр эхэлнэ

Монголын хөрөнгийн биржээс зохион байгуулдаг “Үнэт цаасны зах зээлийн анхан шатны мэдлэг олгох” сургалтыг Санхүүгийн зах зээлд ажиллаж буй Санхүүгийн Зохицуулах

Хороо, Монголын Хөрөнгийн Бирж, Монголбанк, Брокер дилерийн компаниуд болон бусад мэргэжлийн байгууллагуудын удирдлагууд, туршлагатай ажилтан, мэргэжилтнүүд

Дэлгэрэнгүй мэдээллийг www.mse.mn хаягаар эсвэл 11-313747 утсаар авна уу.